

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Буд	Дугаар	L130
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Наран
Төрсөн газар	Наран	Төрсөн он	
Ажил мэргэжил	Наран сумын иргэн		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Молцогийн хийд	Сүм хийдийн дугаар	СБНР 009
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Наран сумын Молцогийн хийд

-Наран сумд байсан сүм хийдийн тухай өөрийн сонссон дуулснаа хэлээч?

Гүн худаг, Сайн худаг, Молцогийн хийд гээд байсан.

Баян молцог 1000 бурхантай, мянга орчим ламтай тийм хийд байсан.

Баян Молцогт бүрээ үлээдэг Дамбий гэж хувилгаан хүн байсан.

Баян Молцог лус уул.

Алтан овоонд хүрэн морьтойгоо очих уул

Хонгор бол хар морьтойгоо очих уул

Дарьгангын сүм Хонгорын өвөрт сүм байсан гэж ярьдаг. Молцог

Баян сайхан сүмтэй

Бадам сайхан шүтээнтэй

Мянга мянган лам нартай

Лхам , Чойжин шүтээнтэй

Баруун хөх мандаатай

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баян молцог хийд гэж дууддаг.

Молцогт бурхан хийдэг шавар байдаг.

Баян далай уул ч гэдэг Баян молцог ч гэдэг нэртэй.

Вангийн цагаан овоог эмэгтэй овоо хатан нь гэдэг юм гэнэлээ.

Баян Молцогийн магтаалууд Алтан овооны бүх судар дээр байгаа. Молцог нь хар морьтой очно. Хонгор нь хүрэн мортой ирнэ гэсэн байдаг. Гомбо сахиустай болов уу гэж боддог.

-Молцогийн хийдийн төвд нэр нь юу гэдэг байсан юм бол?

Төвд нэрийг би мэдэхгүй.

-Молцогийн хийдийн мяндагтангуудын нэрийг мэдэх үү? Хийдийн хамба лам нь хэн байсан бэ?

Их, бага хоёр шүнлайв нь хамба лам нь байсан. Торой банди 30-н хэдэн онд Бадарчин гэдэг хүн байсан тэр нь Алтан овоо гэж нэр өгье гэж тахиад хувиараа алтан ганжирыг барьж Завхан аймгийн Отгонтэнгэр уулнаас арц, уулын модыг газар тавихгүй авчирч Алтан ганжирыг нь хийж байсан. Тэгсэн Алтан ганжирыг аваад явчихсан. Алтан овоо 4 аймаг 7 хошууг харсан цагаан морьтой овоо гэдэг. Зүүнтэй харагдаж байгаа Баяндалай уул 1000 цэрэг хоёр дуулгатай баатраар харуулж байгаа уул.

Алтан овоо бол Гомбо сахиустай овоо Овоон дээрээс Дуут нуурыг харж идэж уух гээд бүх л зүйлийг харж болдог Нэг ёсны толь нь юм.